БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Н.НАРАНЗАЯА

МАЛ УГААЛГЫН СУУРИН ВАННЫ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Асуулт	Барааны техникийн тодорхойлолт, стандартын шаардлага
1.1.	Стандартын шаардлага	*Бог мал угаах суурин байгууламжинд тавих ерөнхий шаардлага MNS 6938 :2021*
1.2.	Баталгаат хугацаа:	*3 жил*
1.3.	Бог мал угаах суурин байгууламжинд тавих ерөнхий шаардлага MNS6938 :2021 стандартын шаардлага болон байгаль орчины эрүүл ахуйн шаардлагыг хангасан мал угаалгын /ванн/суурин байгууламж	Мал угаах суурин байгууламж/ ванн/ нь дор дурьдсан болон түүнээс багагүй техникийн үзүүлэлттэй шинэ төхөөрөмж байна.
		Ерөнхий бүтэц : ➢ Бог мал угаах суурин байгууламж нь төмөр бетонон хана, шал бүхий ванн, гарах өгсүүр хоолой, бэлтгэл, хүзүүвч хашаа, түр зогсоол, түр зогсоол тойрсон хаалгатай битүү хашаа зэргээс бүрдэнэ. /Хавсралт А/
		1. Бэлтгэл хэсгийн хашаа: ➢ Малыг хаших зориулалт бүхий хашааны талбайн диаметр 15м-ээс багагүй, шон нь турбагаар, хашааны хүрээ нь 3мм-ийн зузаантай, дотор савх нь 2мм-ийн зузаантай 3-ын квдрат төмөрөөр, савх хоорондын зай 15-20 см зайтай байна. ➢ Байгууламжийн доторх нийт талбайг бетон хучилттай хийх. ➢ Суурилагдсан хашааны өндөр 1.2 метрийн хэмжээтэй, хашаа нь 20-50 см-ийн бетонон хундаамтай, Хашааны тойргын урт 41м/ хундаамны хамт 22мкв чулуу хэрэгцээтэй/, ➢ Ажлын уусмал бохирдохоос сэргийлэх зорилгоор умбуулахад бэлтгэх хашаан дотор хүзүүвч хашааны тус газраас хойш нийт талбайн бүх гадаргууг (10-15) см-ийн зузаантай хатуу хучилттай хийж өгнө Хашааны тойргын талбай 137мкв/20,4мкуб зуурмаг хэрэгцээтэй/ ➢ Мал тууж оруулах, шахах зорилгоор умбуулахад бэлтгэх хэсгийн дотор талд мал шахах дугуйт хаалт болон хоолой хашаа нэмэлтээр хийж болно. Энэ тохиолдолд бэлтгэх хашааны гадна талын хүзүүвч хашаа байхгүй байж болно.
		2. Мал дамжих хоолой : ➢ Мал умбуулахад бэлтгэх хэсгээс мал угаах хэсэг рүү дамжин өнгөрөх зориулагдсан өргөн 2.4 м, урт 3.0 м, өндөр 1.2 м хэмжээтэй чулуун, бетон шалтай хашаа байна. Хүзүүвчний хоолойн хашааны нийт урт 10м, хундаамны хамт 6мкуб чулуу шаардлагатай, талбайн хэмжээ 7,2мкв, 1,1мкуб зуурмаг шаардлагтай
		3. **Мал умбуулах буюу цүнхээлийн хэсэг** ➢ Бог мал угаах суурин байгууламж дахь уусмалын эзэлхүүн 7 $м^3$-аас багагүй хэмжээтэй байна ➢ Мал умбуулах хэсэгт цүнхээлийн гадна хананы дагуу 1.2 м өндөр төмөр хашаатай байх ба хашааны дотор талын ханыг газрын гадаргуугаас 0.5 м-ээс багагүй зайд битүү доторлоно. ➢ Цүнхээлийн тавцан нь 2.0 м х 1.2 м хэмжээтэй хоёр тийшээ гүйдэг замтай, квадрат хөндий төмөр рамтай, модон буюу

		төмөр хийцтэй, битүүмжлэл сайтай, дуу тусгаарлагч резинэн зөөлөвч дэвсгэртэй байна. Лист төмрийн зузаан 0.3 мм-ээс багагүй байна. ➢ Цүнхээлийн тавцан, гүйх зам, тавцангийн дугуй нь 750-1000 кг-ыг даах даацтай байх ➢ Мал умбуулах хэсгийн цүнхээлийн гүн 1.8-2.0 м, өргөн 2.4 м, урт 2.0 м байна. Цүнхээл, мал гарах хоолойн хана, улыг 25-30 см-ийн зузаан бетон цементэн зуурмагаар доторлоно. ➢ Трапец хэлбэрийн цүнхээлийн амсар хэсгийн өргөн 2.4 м, үзүүр хэсгийн өргөн 1.0 м, урт 1.5 м хэмжээтэй байна ➢ Цүнхээл, хоолойн багтаамжийн хэмжээ, түвшинг тодорхойлон, цүнхээлийн хананд 1 $м^3$ тутамд тусгай тэмдэглэгээг ялгарахуйц өнгөөр хийж өгнө ➢ Бохирдсон ажлын уусмалыг *мотофомпоор* соруулж гаргахад хялбар байхаар цүнхээлийн ёроолын гадаргууд 20 см-ийн диаметртэй хүйс гаргана.
		4. Цүнхээлээс мал гарах хоолой ➢ Цүнхээлд шумбасан мал эмийн бэлдмэлийн шингэн дундуур өгсүүр замаар гарна. Цүнхээлийн үзүүр хэсгээс гарах талбай хүртэлх зай 4 м урт, 0.27 налуу байна. ➢ Гарах хоолойн дотор хананы хоорондын зай 1,0 м өргөн байх ба хоёр талын хана дагуу 1.0 м-ээс ихгүй өндөр, 4м урт чулуун хашаа хийнэ. Хашааны нийт урт 8м, хундаамны хамт 4мкв чулуу шаардлагтай ➢ Мал хальтрахаас сэргийлэх зорилгоор мал гарах хоолойн өгсүүр бетон ул нь хөндлөн чиглэлдээ эржгэртэй байна
		5. Уусмал шавхах хэсэг ➢ Угаалгаас гарсан малын ноосонд шингэсэн ажлын уусмалыг сэгсрэх, шүүрүүлэн ваннд эргүүлэн өөрийн урсгалаар оруулах зориулалтын талбай нь 1.2 м өндөр чулуун хашаагаар хүрээлэгдсэн байна. Хашааны тойргын нийт урт 16м, хундаамны хамт 7,3мкуб чулуу шаардлагтай ➢ Уусмал шавхах талбай нь 5 м-ээс багагүй диаметр бүхий 0.03-ийн налуу, 10 см-ийн зузаан хатуу бетондсон гадаргуутай байна. *Хашааны тойргын талбай 20мкв, 3мкуб зуурмаг шаардлагатай*
		6. Бохирын цооног ➢ Бохирын цооногийн гүн 2-3 м, урт 2 м, өргөн 2-2.5 м хэмжээтэй, цооногийн багтаамж 8-12 $м^3$, газрын хөрсийг ухаж хийнэ. ➢ Бохирын цооног нь мал угаах суурин байгууламжаас (10-15) м-ийн зайд байрлана. ➢ Бохирын цооногийн дотор талын хананы шороог нурахаас хамгаалж, 5см-ийн зузаан банз эсвэл цементээр доторлоно ➢ Цооног нь мотофомпны шланк орох нүхтэй таг хийж өгнө. Модон таган дээр шороо хийж овоолно.

А Хавсралт: Бог мал угаах суурин байгууламжийн ерөнхий тойм зураг



Б Хавсралт: Бог мал угаах суурин байгууламжийн талбайн хэмжээ

БАЙГУУЛАЛТ
М1:100



Д/Д	Нэр
1	Бог малыг умбуулахад бэлтгэх талбай
2	Хүлээгчний хэсэг
3	Цүнхээлийн тавцан
4	Цүнхээл
5	Банн
6	Умбуулсан хэсгийн түр хаших зогсоол

ОСНБ ЗТ	"Бог мал угаах суурин ванны ажлын зураг"				
	Байгуулгын				Үе шат: А/Т
	Архитектор	А.Баяргүйдэй	ЕГ Шифр:	Масштаб: М1:100	Огноо: 2021
	Гүйцэтгэсэн	А.Баяргүйдэй	ТГ Шифр:	Зураг дугаар: БА-1-1	Хуудас: 8
	Шалгасан	Р.Цэтэнмөрөн			

ОСНБ ЗТ
ОСНОО ЗУРАГ
ИНЖЕНЕР БАЙГУУЛАЛТ
ЗУРАГ ТӨСӨВ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ